

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234711

ХОРЧИН НУТГИЙН АЯЛГУУНЫ НЭГЭН АМАН СУРВАЛЖИЙН
ҮГИЙН САНГИЙН ОНЦЛОГИЙГ ТОДРУУЛАХ НЬ

М.Жавхлан

Түлхүүр үг: аман бичгийн хэл, хорчин аман аялгуу, эртний үг, бэнсний үлгэр, гурван улсын үлгэр

Удиртгал

Бичгийн хэлийг “ном бичгийн хэл”, “аман бичгийн хэл” гэх хоёр зүйл хувааж болно. Тус өгүүлэлд бэнсний үлгэр “Гурван улсын үлгэр”-ийг аман бичгийн хэлний сурвалжид хамруулан үзэв.

Хорчин аман аялгууны тухайн сурвалжийг 1984 оны 8 сард Хөлөнбуйрын радио хороонд 62 цагаар шингээн нэвтрүүлсэн юм. Монгол хэлний үгийн сангийн судлалд бэнсний үлгэр, хуурын үлгэрийг хараахан дутуу хамруулж байгаа билээ. Бид энэ удаа тухайн аудиоог эх сурвалжаа болгон хорчин аман аялгууны эртний 14, авианы хувьсал бүхий 18, бусад аялгуунаас үгийн бүтцээр ялгаатай 9, бусад аялгуутай адил боловч найруулга хэрэглээний ялгаатай 22, тухайн аялгууны өвөрмөц 18 үг хэмээн ангилан тайлбарлаа.

Нэг. Хорчин аман аялгууны эртний үг

ᠬᠣᠷᠴᠢᠨ ᠠᠮᠠᠨ ᠠᠶᠢᠯᠭᠤ ᠨᠠᠭᠢ ᠠᠮᠠᠨ

ᠰᠣᠷ - Хорчин аман аялгуунд “харамч хүмүүн”-г ᠰᠣᠷ hu:n гэдэг байна. Тэгвэл, “Шорлого” нь яагаад хорчин аман аялгуунд харамч хүмүүнийг “шор хүмүүн” хэмээн хэлдэг болсныг тайлбарлахаас өмнө шор гэх үгийн гарлыг мөшгөвөл:

“МНТ”-ны 12-р зүйлд Чингис хааны дээд өвгийн нэг Добу мэргэн гэгч гөрөөлж яваад ой дотор буга алж авид хавиргыг нь шарж байсан урианхай хүнтэй уулзсан тухай хэлжээ. Тэгвэл 13 дугаар зүйлд 那可兒 失羅 中合 荅 / nökör širölqa da хэмээн гарч буй бөгөөд širölqa хэмээх хажуугийн орчуулгад 燒肉 與的 хэмээн тэмдэглэсэн байна. Үүнээс харвал 14 дүгээр зууны үед “МНТ”-ны хятад товч орчуулгыг хийсэн эрдэмтэн түшмэд “широлга-да” гэдэг үг “шарах мах өгөөч” гэсэн үг хэмээн ойлгосон нь харагдаж байна. Энэ нь мах гуйсан утгатай үг мөн байсан тулд тэр урианхай хүн “Өгье” гэж хариулаад арьс зүлдийг өөрөө авч махыг Добу мэргэнд өгсөн байна. Тэгвэл тус үгийн талаар судлаачид: “ᠠᠮᠠᠨ”

буюу “*шор*” гэсэн үгнээс үүсэлтэй (Ж.Цэвээн 1936:24), “сиролга буюу широлга (шорлого) гэдэг үгийг “шарах” гэсэн үйл үг (П.Пеллио 1944: 105-109), “шарах мах өгөөч” гэсэн утгатай. -даа/-дээ гэдэг шиг хүч нэмэгдүүлэх сул үг (А.Мостарт 1949: 470-476), “нөхрийн чанар шорлогодоо мэдэгдэнэ” гэсэн утгатай зүйр үг [Ш.Гаадамба 1976:26], “Түрэг хэлний ширалга хэмээх нь ав буюу булааж олсон юмыг хуваах хувь” (Элдэндэй, Ардажав 1986: 26), “шоролга” (Д.Цэрэнсодном 1993: 279), “шорлогд” ангийн хувь хишиг шорлог өг (Ш.Чоймаа 2011:11), “шорлого” (Ц.Сэнгээ 2004: 250) гэсэн байна.

Хэдийгээр харилцан адилгүй саналыг судлаачид дэвшүүлсэн боловч энэхүү “шор” хэмээн үгийн ирэлт нь “широлга” юм. Мөн одоо ч монголчуудын дунд энэхүү ангийн болон мал гаргахдаа гэдэс дотроос нь хуваан хишиг тарааж өгдөг заншилтай адил байна. Хорчин аман аялгуунд “шор хүмүүн” нь “шор долоолгоху үгүй” гэдэг хэвшмэл үгтэй утга ойролцоо байна.

Энэ нь хүнд юу ч өгдөггүй, нарийн хүн, харамч хүн, нүүдэлчдийн ангийн олзоо тааралдсан хүнд хуваадаггүй байдлыг тусгасан байна. Үүнээс гадна, хорчинчуудын дунд “шорондоо” гэдэг хэвшмэл хэллэг байдаг нь мөн үүнээс улбаатай билээ. “Шорондоо” гэдэг нь “хохь нь тэр” гэдэг утгатай бөгөөд одоогийн ордос нутгийн аялгуунд мөн шор хэмээн өөрийн хийсэн үйлдээ хор амсжээ гэсэн санаатай хэрэглэгдэж байна.

Тус сурвалж дахь утга нь эртний монголчуудын шороор агнаж байсан агнуурын зан үйлээс ирсэн болов уу. Шороор агнах гэдэг нь “эрхийн чинээ бүдүүн, далим хир урт далдуу буюу царсан модон шорыг газарт цувруулан шааж тавихыг хэлнэ. Туулай зээрийг агнахад шор тавьдаг. Туулай бол чихээ дарж, нүдээ аньж гүйдэг. Тавьсан шор харайлтын зайд зохицсон бол гарцаагүй шорлогддог”, “Төмөр, модны үзүүр этгээдийг шумгай хийж аливаа хатгахуйд хэрэглэхийг нь шор хэмээмүй. Бас хоёр салгадай хийж, мах шархад хэрэглэхийг нь мөн шор хэмээмүй” монгол хэлний тайлбар тольд хэмээн тайлбарлажээ.

“Шор долоолгохгүй” гэдэг нь шорлогийн махыг өгөхийг бүү хэл шор дамрыг нь ч өгөхгүй гэдэг утга байх бөгөөд “шор хүмүүн” гэдэг хэллэгийн “шор”-той холбоо бүхий харамч гэдэг утгатай байна. Энэ мэт хорчин аман аялгуунд эртний монгол хэлний ямар нэгэн авианы онцлог буюу монгол хэлний авианы хөгжилтийн онцлогийг үзүүлж буй үгс олон буй.

ᠰᠣᠷᠴᠢᠨ ᠠᠮᠠᠨ ᠠᠶᠢᠯᠭᠤᠨᠳᠤ ᠲᠤᠰ ᠤᠮᠤ ᠰᠤᠷᠢᠮ ᠦᠳᠤ “ᠵᠠᠮ” ᠬᠡᠮᠡᠭᠡᠬᠡ ᠤᠲᠦᠭᠢᠯᠢᠭᠡᠢᠨᠢ

tur - Хорчин аман аялгуунд тус үг нь зарим үед “зам” хэмээх утгыг илтгэнэ. Жишээлбэл, хорчин монголчууд цагаан сарын шинийн нэгэнд өлзий бэлгэтэй зүг гарч дахин буцаж ирдэг заншилтай бөгөөд үүнийгээ “мөр гаргах” хэмээн нэрлэдэг. Тус үг “Монголын нууц товчоон”-д §192 “*qorčïn turqa’ut bawurčïn e’üdečïn mün mün mör-dür-iyen yabu=tuqai*” 中豁^舌兒^臣 土^舌兒^中合^兀 揚 保兀^舌兒^臣 額古迭臣門 門 抹^舌兒^都里^顏 迓步秃^中孩^中 хэмээн илэрдэг бөгөөд арын тайлбарт нь “тэр тэр замаараа” гэж тайлбарлажээ (Элдэндэй, Ардажав 1986: 378). Хорчин аман аялгуунд хэлэгдэж байгаа “мөр гаргах” гэдэг үг нь “зам гаргах”, “зам нээх” гэдэг утгатай байгаа нь тодорхой. Бидний мэдээжээр, орчин үеийн монгол хэл аялгууны “зам” гэх үг бол эртний хятад хэлний “站” (өртөө, 站) гэх үгнээс гаралтай байж, “мөр” гэвэл хүмүүн амьтны хөлийн ормыг заадаг. Дундад эртний

монгол хэлэнд “зам”-г “мөр” гэж хэлж байсан байх боломжтой. Үүнийг бид зарим сурвалж бичиг хийгээд монгол төрөл хэлний материалаас мэдэж болно. Жишээлбэл, “Хуа и и юй” мог (зам), Монгор хэл mvr (зам), Дуншаан хэл mo (зам), Баоан хэл mcr (зам) гэх мэт.

ᠰᠠᠮ ᠵᠢᠨ ᠬᠠᠭ ᠰᠢᠬᠤᠯᠠᠭ ᠮᠣᠳᠤ ᠦᠲᠦᠭᠦᠨ ᠪᠠᠯᠠᠷ ᠣᠶᠢ ᠭᠡᠰᠡᠨ ᠤᠮᠤᠯᠠᠭᠤᠨ

хаг tu᠒ - ягч сахлаг мод, өтгөн балар ой гэсэн утгатай. Олонхдоо “хар түн”, “модон түн”, “түн хар мод” гэж холбон ярьдаг бөгөөд ардын дууд “түн хар модоор түшлэг хийсэн” гэж гардаг байна. Жишээгээс мэдэж болох нь тус үг нь хэдийгээр ягч сахлаг ой модыг заадаг боловч утгын хувьд “харанхуй, хар” гэсэн утгатай болох нь мэдэгдэж байна. Тус үг “Монголын нууц товчоон”-д “Ононы түнд хуримлахуйд, 斡難訥 屯圖兒 中忽林刺恢突兒” (§50), “Ононы түн дотор хэвтвээс үзэгдэх хэмээж, усны харигт гэдрэг харж хэвтэж, бугуугаа усан уруу урсган, нүүр ил хэвтэв./ 斡難訥屯 朶脫朶刺 客帖額速 兀者迭古 客額周 兀速訥 中合兒乞圖兒 格迭兒古 客迭周 不中合兀班 兀孫 忽朶魯兀 兀朶魯思 中罕 你兀兒 亦列 客迭罷” (§81) Ван ханыг Туулын Хар түнээ (түнд) буюу (байна) хэмээн мэдэж одов./ 王 中合泥 土兀刺因 中合朶刺 屯捏 備由 客延 篋迭周 斡罷 (§96) гэж “түнд”, “түн”, “хар түнээ” гэх мэтээр 11 удаа тохиолдож буй бөгөөд хажуугийн орчуулгаас харахад “林” “шугуй” гэж мэдэж болохоор байна. “Монгол үгсийн язгуурын толь”-д балар ой шугуй, түн ч хэмээн тэмдэглэсэн байна (Сэцэнцогт 1988: 1988). “Монгол хэлний толь”-д өтгөн балар ой, даяаг түн хэмээжээ (Ц.Норжин, М.Мөрөн 1986: 2444).

ᠬᠠᠭ ᠰᠢᠬᠤᠯᠠᠭ ᠮᠣᠳᠤ ᠦᠲᠦᠭᠦᠨ ᠪᠠᠯᠠᠷ ᠣᠶᠢ ᠭᠡᠰᠡᠨ ᠤᠮᠣᠯᠠᠭᠤᠨ ᠬᠠᠭ ᠰᠢᠬᠤᠯᠠᠭ ᠮᠣᠳᠤ ᠦᠲᠦᠭᠦᠨ ᠪᠠᠯᠠᠷ ᠣᠶᠢ ᠭᠡᠰᠡᠨ ᠤᠮᠣᠯᠠᠭᠤᠨ

ixүн- Бэргэн, тус үг нь дөрвөд, жалайдын уугуул настайчуудын ярианд л хэрэглэгдэж байна. “Монголын нууц товчоон”-д “qamuc-un qahan ulus-un ejen bol=ju öki-ben ö’esün hüde=küi-ben nama-ar kese:=tkün./ 中合木渾 中合罕 兀魯孫 額訛 孛魯周 斡乞邊 斡額孫 許迭恢邊 納馬阿兒 客薛 坤” (§53) гэж тэмдэглэсэн бөгөөд “öki”-ийг хажуугийн орчуулгад “女子 буюу охин” хэмээн тайлбарласан байна (Элдэндэй, Ардажав 1986: 27). “Хорин нэгт тайлбар толь”-д эгчийг өгий хэмээмүй гэжээ (ХНТТ 1979: 607). Эртний баатарлаг тууль “Тэсэр”-т “өгий” гэж эгчийг заасан байна (ТҮБГТ 1986: 9). “Монгол хятад толь”-д “өгий” гэж “大姐” (МХТ 1999: 278) гэж тайлбарлажээ. Барга аман аялгуунд “нагац эх”-ээ cfī: гэж дууддаг (Шинэдхэ 1987). Дээрх байдлаас ажиглавал cfī: гэх үг нь утгын талаар uhi:-тай ялгаатай боловч эм хүйсийг заасан шинжээрээ нэгдэлтэй байна. Зарууд нутгийн зарим монголчууд бэргэнээ juᠨ ga: гэж дууддаг. Баргад xun hai гэж, цахарт xin ge:ge: гэж ярьдаг.

ᠬᠠᠭ ᠰᠢᠬᠤᠯᠠᠭ ᠮᠣᠳᠤ ᠦᠲᠦᠭᠦᠨ ᠪᠠᠯᠠᠷ ᠣᠶᠢ ᠭᠡᠰᠡᠨ ᠤᠮᠣᠯᠠᠭᠤᠨ

am үws- Хуурай будаа (хуурсан амуу) нь монгол амууг галд хууран гаргадаг. “Ааг байх хар амууг буцлам усанд нэг удаа хийлгэж дахиж нарийн хоомогийг тогоо дотор хийж арвин гал хийхүйд энэ хомог гал мэт улайн хоомогт хутгаж амууг хаг хаг дугартал хуураад авсан хойно уураа тохорж цайлгаж хөхөрсөн амуу хэмээн нэрийдэж...” (Ванжил 1999: 206) гэж монгол амуугаас хуурай

будааг гаргах явцыг танилцуулсан байна. Хуурай будааны түүхий материал болох монгол амуу нь шим тэжээлээр өндөр, нэгэн зүйлийн таримал ургамал болно. Монгол амууны тухай “Үрт ургамлын зурагт толь”-д , “нэг наст өвслөг ургамал, сүрэл нь дандаа сална... Уудам хээр тал, уулын хажуугийн чийглэг газарт ургадаг, нэлээд сайн өвс бордоо мөн. Хөх болон хатсан өвсийг нь морь идэх дуртай” гэж нарийн тайлбарласан байна. Иймээс хуурай будааны түүхийн материал болох монгол амуу нь өвслөг ургамал бөгөөд нэлээд сайн бордоо болох тул “өвс” гэх утгыг “будаа”-тай холбож “хуурай будаа” гэж нэрлэсэн байна.

ᠮᠠᠨᠵᠢ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ
 ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ
 ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ
 ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ
 ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ
 ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ
 ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ
 ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ
 ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ
 ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ

үм- Хуурай будаа нь “эм” гэх утгатай холбоотой байна. Хуурай будааг түүний ашиг тусаас шалтгаалсан “эмийн будаа” хэмээн нэрлэх болжээ. Хуурай будаа болсон байдаг учраас хөнгөн, шингэхэд амархан, шим тэжээл сайтай, өл даадаг, хүний биед хор нөлөөгүй, бусад төрлийн элементтэй амархан урвалд ордоггүй байна. Иймээс монгол эмч нар үрэл, эм найруулахдаа хуурай будааг гол бүрэлдэхүүнээ болгон ашигладаг байна. Мөн манж хэлэнд эмийг “okto”, эмчийг “oktosi” гэдэг байна (Лю Хуо Шөн 1988: 312). Энэ нь эт “эм” гэх баримт болж байна.

Үүнийг харвал хуурай будаа бол эмч нарын эмийн найруулгад хэрэглэж байсан материал болно. Тиймээс хуурай будааг “эмийн будаа” хэмээдэг байжээ. эт бол орчин цагийн монгол хэлэн дахь “оч”-тай гарлын холбоотой бөгөөд “гал, өвс, эм” гэх утга бүхий түрэг гаралтай үг юм. Хорчин монголчууд “хуурай будаа”-г эт bada гэж нэрлэдэг нь хуурай будаа нь галын будаа, өвслөг ургамал, мөн эмийн материал болдог учраас ийн шинж чанараас нь шалтгаалан нэрийджээ.

ᠮᠠᠨᠵᠢ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤ
 ε:l- Хорчин аман аялгуунд олон өрхөөс бүрэлдсэн тосгоныг айл гэдэг байна. Монгол хэлний бусад аялгуу, аман аялгуун дахь байдлыг ажиглавал, Шулуун хөх, Баруун баарин, Дархан, Харчинд ε:l, халх, буриад, хуучин барга, буриад, зүүн сөнид, отог, дагуур, зүүн ёгорт ail, алшаад æ:l, ордос, ойрад āl, Дуншаан хэлэнд аүәен, Баоань хэлэнд ndzva, Монгор хэлэнд ajil гэж байна. Ихэнх газар оронд айл нь нэг өрхийг илтгэдэг байна. Айл нь нүүдэлчин монголчуудын нэг төрлийн амьдралын хэлбэр байсан билээ.

Монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов: “нэг гэр, төрөл садан нь ганц өрх эсвэл бага хот айлаар нүүдэллэн малжин амьдардаг”, “айл нь хэдэн харгуйтай тэргээр бүрэлдсэн малчин өрхийг хэлж буй” хэмээн нүүдлийн соёлтой холбон тайлбарлажээ.

“Монголын нууц товчоон”-ы 84 дүгээр зүйл 《阿泥 塔兒_{中合兀侖} 巴_{舌刺周} 朵脱_{舌刺般} 薛_楊 乞_周 斡_{赤干} 阿_因 必_{秃温周} 中_{豁那温恢突兒} ᠠᠨᠢ ᠲᠠᠭᠢᠯ ᠪᠠ ᠲᠤ᠋ᠲᠤ ᠴᠢᠨ ᠬᠠᠳᠤᠯᠠᠭ ᠠᠨᠢ ᠠᠯᠤᠯ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠬᠠᠳᠤᠯᠠᠭ ᠠᠨᠢ ᠠᠯᠤᠯ „ 107 дугаар зүйл 《脱_{斡_{舌鄰}} 中_罕 你_刊 土_綿 脱_{斡_{舌鄰}} 中_罕 訥_{迭兀} 札_{中合} 敢_不 你_刊 土_綿 中_{豁牙_{舌兒}} 土_{綿的耶_{舌兒}} 乞_{沐_{舌兒}} 中_合 中_{豁_{舌兒}} 訥_{阿因} ᠲᠤ᠋ᠲᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ 中_合 刺_{中合納荅} 保_{兀周} 不_{恢突_{舌兒}} 捏_{亦連} 保_{兀罷} ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ / ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ 122 дугаар зүйл 《乞_{沐_{舌兒}} 中_合 中_{豁_{舌兒}} 羅_{中合訥} 阿_亦 ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ 中_合 刺_{中合納荅} 保_{兀周} 不_{恢突_{舌兒}} / ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ 中_合 刺_{中合納荅} 保_{兀周} 不_{恢突_{舌兒}} 捏_{亦連} 保_{兀罷} ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ 》 ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ 》 дээрх жишээнээс харахад эртний монголчуудын айл хэмээх ойлголт нь нэг л өрх гэрийг илтгэж байна.

Хорчинчууд нүүдлийн соёлоос бага багаар холдон тариалангийн соёл нь гол амьдралын хэв загвар болсонтой тухайн үгийн ойлголт хувирах шалтгаан болсон байх. Тариалангийн аж ахуйг гол амьдралын загвараа болгож түүний суурьшил загвар, харьцангуй тогтуун суурьшдаг онцлог, өрх бүр хэсэг газарт үеэс үед өвлүүлэн уламжлуулах боломжтой зэрэг урт удаан амьдралын хэв маягаас болж хорчинчууд хэсэг газар бүрэлдсэн тосгоны иргэдээ нэг айлын хүн гэж “айл хүний амь нь нэг, саахалт хүний санаа нэг” гэхчлэн ярьдаг билээ. Ийнхүү хорчинчуудын “айл” гэх ойлголт нь хэдэн арван өрхөөр бүрэлдсэн тосгоныг хэлдэг болсон байна.

ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠢ ᠲᠤ᠋ᠳᠤ
 irgün- Монгол хэлний тольд “Улсын иргэд ард, хамаг хүн тухайлбал хар тэргүүтэн, хятад хүн”-ийг хэлдэг гэсэн байна (Ц.Норжин, М.Мөрөн 1999: 366). Тэгвэл толь бичгүүдэд “Тэнгэрийн доорхны хүнийг иргэн хэмээмүй” (ХНТТ 2014: 72), “ард, хүмүүс, харьяат” (Д.Төмөртоогоо 2017: ?) хэмээн тайлбарласан байна. Манж-англи тольд irgen нь ‘people’ буюу хүмүүс, ‘the common people’ буюу энгийн хүмүүс хэмээн тайлбарласан байна (Jerry Norman 2013: 150). Тэгвэл тухайн үгийн талаар С. Калужински (1977) “Монголын нууц товчоон” дахь иргэн ба овог хэмээх үгийн утга, мөн Т. Д. Скрынни-кова (1990) “Монголын нууц товчоон” доторх овог ба иргэн, Р. Rykin (2004) “иргэн ба овгийн тухай ойлголт” гэх мэт тусгайлан судалсан бүтээлүүд бичсэн байна. Ингээд монгол хэлний дурсгалуудад хэрхэн тэмдэглэгдэж, уламжлагдан ирснийг харвал: 1338 оны Жигүүнтэйн дурсгалд зориулсан хөшөөний бичгийн 3 дугаар мөрд “olan qari-yin irgen imayī eŋige metü kündülen ajuyu/олон харийн түүнийг эцэг мэт хүндлэх ажээ”, “Монголын нууц товчоон”-ы 5 дугаар зүйлд иргэн хэмээх үг нь анх тохиолдож буй бөгөөд жишээг харахад “統格黎_克 中_豁 羅_{中罕} 忽_{舌魯兀} 你_刊 孛_孛 亦_兒 堅 耨_{兀周} 斡_{舌羅周} 阿_{亦速} 忽_宜 中_合 舌_{刺周} 兀_{者周} / Tünggelik_qoroqan huru’u niken bölök irgen newü=jü oro=jū ayisu=qu-yī qara=jū üje=jü. Хажуугийн хятад орчуулгад 百姓 эгэл ард, “зуун овог” хэмээн тэмдэглэсэн байна. Иргэн хэмээх үг нь “Монголын нууц товчоон”-д нийт 119 удаа тохиолддог бөгөөд уг хүмүүс, албат олон, улс аймаг зэргийн өргөн утгаар гардаг. Сагансэцэний “Эрдэнийн товч”-ийн 63b талд “qaraču irgen eŋen ügei yaŋin yabumui/харц иргэн эзэнгүй яаж явах”, “Хятад Монголын харилцааны бичиг”-ийн А9 талд “qahan tüšimel

速必迭該^中豁紉^揚 阿都兀刺罷/alaqči'ut qoni<n>d-i adu'ula=ju alam dü'ürge=sü. qongqoqči'ut qoni<n>d-i adu'ula=ju adu'ula=ju Qonjiyasun ide=sü bi. Degei qoni<n>t adu'ula=ba.” энд адуулж гэх хэлбэрээр 3 удаа, адуулав гэж 1 удаа гарч байгаа нь бүгд хариулах маллах гэсэн утгатай байна. Монголын нууц товчоонд “агт” гэж агталсан, нас бие гүйцсэн, эр цэрэг, өртөө улааны унаа болж чадах, шилж сонгосон сайн морийг нэрлэж байна. Харин морь гэж унаж ачиж болох адууг л ерөнхийд нь нэрлэдэг байна. Ш.Чоймаа (2017) “Адуу” гэдэг үг нь орчин цагийн монгол хэл шиг таван хошуу малын нэгнийг нэрлэхийн хамт ихэнх зонхидоо мал сүрэг, мал хөрөнгө гэсэн утгыг илтгэж байсан байна” гэжээ. Эндээс харахад адуу хэмээх нэр үгээс адуулах гэх үйл үг үүссэн байна. Харин “хариулах” гэх үг Монголын нууц товчоонд 11 удаа тохиолдох бөгөөд хариу барих, буцаах, эгүүлэх гэсэн утгаар гардаг ба маллах гэсэн утга огт байхгүй билээ. Эртний монгол хэлэнд адуулах гэдэг нь мал маллахыг хэлдэг байсныг Монголын нууц товчоонд хонь адуулж гэх баримтаас мэдэж болох билээ.

Манжийн төрийн үед Чуулгат хаалганы гадна адуун сүрэг, Шанага боомтын гадна Далинхоогийн зэрэг газрын морь тэмээ адууны үрсэн, унасан тоог хянан байцаахын дээр цагдан гаргахууд дагаж одох түшмэл цэцэгт морь тэмээ хувьчлан өгөх зэрэг хэргийг захиран шийдэх яамыг “Адууг захирах яам” хэмээдэг байсан бөгөөд дээдийн адууны явдлын яамны хэргийг бүгд захирах сайд буюу адууны сайд эрхлэхээс гадна цэргийн адуун сүргийг хариулан маллагч хүнийг агтач, ноён эзний адуун сүргийг хариулан маллагч хүнийг адууч зэргээр нэрлэсэн тусгай албан тушаалууд байжээ. 1755-1758 оны хооронд “Гадаад монголын төрийг засах явдлын яам” байгуулж манжийн төрөөс монголд явуулж байсан бодлого үйл ажиллагааны хүрээнд Манжийн ноёрхлын үеийн албан татварын бодлогын нэг хэсэг манжийн хааны сүрэг, албаны мал адуулах албыг байгуулж манж гүрний хил хязгаарыг батлан хамгаалж байгаа цэргийн хэрэгцээнд зориулан манжийн хааны тусгай сүргийг бий болгон ардуудаар маллуулдаг байжээ. Сүрэг хариулагч ардууд уул сүргийн хорогдлыг нөхөн төлөх, ашиг шимийг нийлүүлэх, зэрэг нэн хатуу болзолтой давхар үүргүүдийг гүйцэтгэдэг байв.

Хорчин аман аялгуунд гахай адуулах гэж хэлдэг бөгөөд энэ нь маллах гэсэн үгийг хэлж буй билээ. Тиймээс, Бүрэнбаяр хуурчийн хэлсэн “Турван улсын үлгэр” дээр гарч буй “адуулж” хэмээх үгийг бид “маллаж” хэмээн ойлговол зохилтой билээ.

ᠬᠤᠯᠠᠭᠤ ᠠᠶᠢᠯᠭᠤᠨᠳᠠᠬᠤᠭᠠᠢ ᠠᠳᠤᠭᠤᠯᠠᠬᠤ ᠭᠡᠭᠡ ᠬᠡᠯᠳᠡᠭᠡ ᠪᠦᠭᠦᠳᠡ ᠡᠨᠢ ᠨᠢ ᠮᠠᠯᠠᠬᠤ ᠭᠡᠰᠡᠨ ᠤᠭᠢᠭᠢᠭᠡ ᠬᠡᠯᠢᠵᠡ ᠪᠤᠢ ᠪᠢᠯᠡᠭᠡ. ᠲᠢᠶᠢᠮᠡᠭᠡᠰᠡ, ᠪᠦᠷᠦᠨᠪᠠᠶᠠᠷ ᠬᠤᠭᠤᠷᠴᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠰᠡᠨ “ᠲᠤᠷᠪᠠᠨ ᠤᠯᠤᠰᠢᠨ ᠤᠯᠭᠡᠷ” ᠳᠡᠭᠡᠷ ᠭᠠᠷᠴᠢ ᠪᠤᠢ “ᠠᠳᠤᠭᠤᠯᠢᠵᠡ” ᠬᠡᠮᠡᠭᠡᠬᠡ ᠤᠭᠢᠭᠢᠭᠡ ᠪᠢᠳᠡ “ᠮᠠᠯᠠᠵᠢ” ᠬᠡᠮᠡᠭᠡᠨ ᠣᠶᠢᠯᠭᠣᠪᠣᠯ ᠵᠣᠬᠢᠯᠲᠣᠢ ᠪᠢᠯᠡᠭᠡ.

хэ:lүн – Өвөр монголд “Хүний чанаж болгосон цагийн идээ, хуурай будааг зөөхийтэй хутгасан идээ/нутгийн аялгуу/, эхийн хөх ба хөхний сүү, гахай нохойнд идүүлэх болгосон идэш/нутгийн аялгуу/, амьтан араатны амьд идэш” гэх зэргээр тайлбарладаг бол Монголд “идэх тэжээлийн зүйл гэсэн үндсэн утгаас гадна хүн, амьтныг хараах үг, бусдын ашиг завшаан болох” гэх шилжсэн утгаар ойлгодог билээ.

Тэгвэл “Монголын нууц товчоон”-ы 26 дугаар зүйлд “亦啞恢 亦啞延 兀該 阿^舌侖 赤那因^中 昆途兒 豁兒^中合^黑 三 戈^舌劣額孫 馬^舌里牙周^中 合兒鑊周 阿刺

周 亦啞^勒 都額^揚 赤那因 亦啞^克 先泥 忝古^勒 都周 亦啞額^揚 斡額^舌 侖^中 豁斡来 荅安
 中合兒赤孩巴安 别兒 帖只額^勒 敦 帖^舌 列 桓 中合兒罷/ide=küi ide'en ügei a=run
 čino:-yin qun-tur qorqa=qsan görö'esün mariya=ju qarbu=ju ala=ju ideldü=et čino:-yin
 ide=ksen-ni temgüldü=jü ide=et ö'er-ün qo'olai-da-an qarčiqai-ba'an ber teji'eldü=n
 tere hon qar=ba гэж байна. Энэ мэтээр Монголын нууц товчоонд нэлээн хэдэн
 удаа тохиолдохдоо “хоол, ходоод, гэдэс” гэх мэт олон утгыг илтгэж байсан.

Хорчин аман аялгуунд хэ:lүн хэмээх үг гахай, нохой, морь зэрэг адгуус амьтны идшийг хэлдэг байна. Хорчин, Баарин зэрэг газар хоол болон хоолой хэмээх хоёр үгийг адил утгаар хэрэглэдэг байна.

Жишээ нь “Миний хоол сөөжээ” хэмээн ярьж буй нь “Миний хоолой сөөжээ” гэх утгыг хэлж буй хэрэг.

Тэгвэл “хоолой” гэх үг нь монгол аялгуунуудад хэрхэн дуудагддагийг үзвэл:

- халх, дөрвөд, хэ:lœ:
- шулуун хөх хошуу, баарин баруун хошуу хœ:le:
- сөнөд, отог хœ:lɔi, хуучин барга
- буриад хэ:lɔi
- алшаа хэ:lɔi
- хорчин, харчин хэ:l , хс:l гэх мэт.

Хоёр. Хорчин аман аялгууны авианы хувьсал бүхий үг

ᠠᠶᠢᠯᠠᠭᠤᠨ ᠠᠮᠠᠨ ᠨᠡᠯᠡᠭᠡᠨ ᠰᠠᠶᠢᠨ ᠳᠤᠭᠠᠨ ᠦᠭᠡᠰ ᠳᠤᠭᠤᠲᠠᠢ ᠰᠤᠯᠤ ᠪᠡᠭᠡᠭᠦᠯᠡᠭᠴᠢ
 ᠔᠑᠔: нэлээн сайн – овоо (овоо сайн) гэсэн үгээс дуутай сул в~г гийгүүлэгч
 сэлгэсэн.

ᠮᠢᠨ ᠠᠶᠢᠯᠠᠭᠤᠨ ᠠᠮᠠᠨ ᠨᠡᠯᠡᠭᠡᠨ ᠰᠠᠶᠢᠨ ᠳᠤᠭᠠᠨ ᠦᠭᠡᠰ ᠳᠤᠭᠤᠲᠠᠢ ᠰᠤᠯᠤ ᠪᠡᠭᠡᠭᠦᠯᠡᠭᠴᠢ
 mi: - юм уу, юм бэ? Гэдэг асуух үгийг ингэж эхний үе гээгдэж хэлдэг.

ᠨᠡᠯᠡᠭᠡᠨ ᠰᠠᠶᠢᠨ ᠳᠤᠭᠠᠨ ᠦᠭᠡᠰ ᠳᠤᠭᠤᠲᠠᠢ ᠰᠤᠯᠤ ᠪᠡᠭᠡᠭᠦᠯᠡᠭᠴᠢ
 nɔ:lɔɔ:ʃɣx - ноолгочих – (оноолгочих) – халх аялгуунд оногдуулчих гэхэд
 үйлдэгдэх хэв, үйлдүүлэх хэв 2 дараалан орсон бол хорчин аман аялгуунд
 үйлдүүлэх хэв 2 удаа орсон байна.

ᠮᠠᠨ ᠢᠩᠭᠡᠲᠡᠯ – энэ 2 үг ярианы урсгалд нийлэхдээ хоёрдугаар үг нь бие
 даасан өргөлтөө алдаж, нэгдүгээр үгийн сүүлийн и гийгүүлэгч сугарч, эгшиг нь
 хоёрдугаар үгийнхээ эгшигтэй ухран ижилссэн байна. Ингээд ярианы урсгалд
 хоёр үг нэг үг болон нийлжээ. Энэ бол хэлний хэмнэлтийн зарчимтай холбоотой
 бөгөөд хорчин аман аялгуу бусад аялгуунаас харьцангуй ярианы хурд ихтэй
 байдагтай холбоотой юм.

- ᠠᠶᠢᠯᠠᠭᠤᠨ ᠠᠮᠠᠨ ᠨᠡᠯᠡᠭᠡᠨ ᠰᠠᠶᠢᠨ ᠳᠤᠭᠠᠨ ᠦᠭᠡᠰ ᠳᠤᠭᠤᠲᠠᠢ ᠰᠤᠯᠤ ᠪᠡᠭᠡᠭᠦᠯᠡᠭᠴᠢ - ᠔᠑᠔:
- ᠠᠶᠢᠯᠠᠭᠤᠨ ᠠᠮᠠᠨ ᠨᠡᠯᠡᠭᠡᠨ ᠰᠠᠶᠢᠨ ᠳᠤᠭᠠᠨ ᠦᠭᠡᠰ ᠳᠤᠭᠤᠲᠠᠢ ᠰᠤᠯᠤ ᠪᠡᠭᠡᠭᠦᠯᠡᠭᠴᠢ - nɔ:lɔɔ:d
- ᠠᠶᠢᠯᠠᠭᠤᠨ ᠠᠮᠠᠨ ᠨᠡᠯᠡᠭᠡᠨ ᠰᠠᠶᠢᠨ ᠳᠤᠭᠠᠨ ᠦᠭᠡᠰ ᠳᠤᠭᠤᠲᠠᠢ ᠰᠤᠯᠤ ᠪᠡᠭᠡᠭᠦᠯᠡᠭᠴᠢ - nɔ:lɔɔ:ʃɣx
- ᠠᠶᠢᠯᠠᠭᠤᠨ ᠠᠮᠠᠨ ᠨᠡᠯᠡᠭᠡᠨ ᠰᠠᠶᠢᠨ ᠳᠤᠭᠠᠨ ᠦᠭᠡᠰ ᠳᠤᠭᠤᠲᠠᠢ ᠰᠤᠯᠤ ᠪᠡᠭᠡᠭᠦᠯᠡᠭᠴᠢ - mi:
- ᠠᠶᠢᠯᠠᠭᠤᠨ ᠠᠮᠠᠨ ᠨᠡᠯᠡᠭᠡᠨ ᠰᠠᠶᠢᠨ ᠳᠤᠭᠠᠨ ᠦᠭᠡᠰ ᠳᠤᠭᠤᠲᠠᠢ ᠰᠤᠯᠤ ᠪᠡᠭᠡᠭᠦᠯᠡᠭᠴᠢ - mi:
- ᠠᠶᠢᠯᠠᠭᠤᠨ ᠠᠮᠠᠨ ᠨᠡᠯᠡᠭᠡᠨ ᠰᠠᠶᠢᠨ ᠳᠤᠭᠠᠨ ᠦᠭᠡᠰ ᠳᠤᠭᠤᠲᠠᠢ ᠰᠤᠯᠤ ᠪᠡᠭᠡᠭᠦᠯᠡᠭᠴᠢ - mi:
- ᠠᠶᠢᠯᠠᠭᠤᠨ ᠠᠮᠠᠨ ᠨᠡᠯᠡᠭᠡᠨ ᠰᠠᠶᠢᠨ ᠳᠤᠭᠠᠨ ᠦᠭᠡᠰ ᠳᠤᠭᠤᠲᠠᠢ ᠰᠤᠯᠤ ᠪᠡᠭᠡᠭᠦᠯᠡᠭᠴᠢ - myŋtyl

Дүгнэлт

Хуурч Бүрэнбаяр хуурдан хэлсэн тухайн үлгэрийн үгийн сан дахь олон арвин нутгийн аялгуунд хадгалагдан үлдсэн эртний үг хэллэг, тухайн цагийн хорчин аман аялгууны үгс нь нэн чухал сурвалж, дурсгал болно. Энэ нь хорчин аман аялгуун дахь зарим эртний үг нь утгын хувьд хэвээр хадгалагдсаар байна. Хэл нь хэлбэр ба утгын нэгдмэл цогц болсны хувьд хэлний хувиралтад авианы хувиралтыг багтаалгүй утгын хувиралтыг багтааж үзлээ. Хорчин аман аялгуун дахь иргэн, улс, адуулах гэх мэт үгийн утга нь дундад үеийн монгол хэлний үгийн утгаа хадгалж байна. Харин хорчин аман аялгуунд хэрэглэгдэж байгаа эртний үг нь бичгийн хэлэнд нэгэнт гээгдэж хэрэглэгдэхээ больсон ба зарим тохиолдолд бичгээс аманд уламжлан үлддэг болохыг энэ аман бичгийн хэлний дурсгалаас харж болно. Бүрэнбаяр хуурч нь бичгийн боловсрол өндөр, хуурчийн уламжлалыг сайтар өвлөн авсан нь амнаас аманд өнө удаан хугацаагаар уламжлагдан үлдсэн үг хэллэг, бичгийн сурвалж дахь үг хэллэгийг биеэр тээж уг 62 цагийн үлгэртээ шингээлгэсэн нь үгийн санг задлан үзэхэд илэрч буй эртний үг хэллэг бичгийн сурвалж ч тэмдэглэгдэх боломжгүй нутгийн аялгууны үг хэллэг зэргээс ажиглаж байна.

1984 оны хорчин аман аялгууны дурсгал болох энэ сурвалжид илэрч буй хорчин аман аялгууны үгсийн одоогийн зарим хорчин нутагт харилцан адилгүй хэрэглэж буйгаас мөн өнөөдрийн хорчин аман аялгууны хувьсал өөрчлөлтийг мэдэж болох судалгааны давуу талтай билээ. Хуурч Бүрэнбаярын хэлсэн “Гурван улсын үлгэр” дэх хорчин аман аялгууны үгсийг авианы хувьсал бүхий үгс, бусад аялгуунаас үгийн бүтцээр ялгаатай үгс, бусад аялгуутай адил боловч найруулга хэрэглээний ялгаатай үгс, тухайн аялгууны өвөрмөц үг хэмээх дөрвөн хэсэгт хуваан ангилан тайлбарласан болно. Хуурын үлгэрийн шингээлт нь харилцан адилгүй цаг үед шингээн нэвтрүүлж байсан бөгөөд энэхүү аман бичгийн сурвалжууд нь хорчин аман аялгууны судлалд нэн чухал баримт болж байна.

Ном зүй

- Гаадамба 1976 – Гаадамба Ш. Монголын нууц товчооны нууцаас, Улаанбаатар, 1796.
- Чоймаа 2011 – Чоймаа Ш. Монголын нууц товчоо эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг, Улаанбаатар, 2011.
- Халиун 2014 - *Халиун Л, Чоймаа Ш.* Дарма гүүш Алтан хүрдэн мянган хигээст, Улаанбаатар 2014.
- Шагдарсүрэн 2014 - Шагдарсүрэн Ц, Мөнх-Учрал Э, Чоймаа Ш. Монголын эртний хаадын үндэсний их шар тууж оршвой, Улаанбаатар, 2014.
- Чоймаа 2017 – Чоймаа Ш. Монгол сурвалж судлал эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган, Монгол Улсын Их Сургуулийн профессорын өв, I дүгээр боть, Улаанбаатар 2017.
- Kā lǎ qìn yòu qí bèizi hǎishān biānyì “méng hàn hébì wángfāngyuán yīn xù”, zhōnghuá mínguó liù nián zhōngchūn chūbǎn. 喀喇沁右旗贝子海山编译《蒙汉合璧王方元音序》，中华民国六年仲春出版。(1917)
- Цэвээн 1936 - Жамцарано Ц. Монгольские летописи XVII века, Труды Института Востоковедения, XVI, Москва-Ленинград, 1936.
- Pelliot 1944 - P.Pelliot široᠯᠠ ~ širalᠤ _ “T’oung pao”, 1944, XXXVII, 3-4, 105-109 page
- Mostaert 1949 - A.Mostaert, A propos du mot sirolga de L’Histoire secrete des Mongols, _HJ of Asiatic Studies, Vol. 12, 1949, 470-476.
- Tuō dā yé wá 1957 - “xiàndài ménggǔ biāozhǔn yǔ yǔfǎ jiǎngyì”, zhōngyāng mínzú xuéyuàn, 1957 nián,

- dì 17-20 yè. 布·哈·托达叶娃“现代蒙古标准与语法讲义”，中央民族学院，1957年，第17-20页。
- Sün Jü 1976 - Sün Jü. Ulus-un dotuyadu daki Mongyol kelen-ü nutuγ-un ayalyun-u qubiyarilal kiged barimjüy-a abiyun-u asaγudal-un tuqai. MKUJ. 14-30.1976 on
- С. Калужински, О значении слов *irgen* и *obog* в ‘Сокровенном сказании’, ОУМЭИХ III, т. II, 1977, 79-85
- Qorin nigetü tayilburi toli, [Хорин нэгт тайлбар толь] *öbür mongyul-un arad-un keblel-ün qoriy-a, Kökeqota*. 1979.
- Tiě mù 1982 - Tiě mù “ménggǔ yǔ kē'ěrqn tán yuán”, nèiménggǔ dimíng, 1982 nián dì 4 qī. 铁木“蒙古语科尔沁谈源”，内蒙古地名，1982年 第4期。
- Todu üsü-eče bayulγaysan geser-ün tuγuji, [Тод үсгээс буулгасан гэсрийн тууж] *ulaγanqada-yin nigedüger keblekü üyiledbüri, Ulaγanqada* 1986
- Eldendei 1986 - Eldengdei, Ardajav. *Mongyul-un niγuča tobčiyun-u seyiregülül tayilburi. Öbür mongyol-un surγan kümüjil-ün keblel-ün qoriy-a. Kökeqota*. 1986.
- Sinedke, barγu buriyad nutuγ-un ayalyun-u üge-yin sang-un tal-a-bar ki öbermiče ončaliγ, *öbür mongyul-un yeke surγayuli-yin erdem šinjilgen-ü sedkül, Kökeqota*. 1987.3
- 刘厚生等《简明满汉辞典》，河南大学出版社，1988年，312页。
- Т. Д. Скрынни-кова, ‘Обоγ’ и ‘irgen’ в контексте ‘Сокровенного сказания’, *Mongolica* 1 (22), 1990, 92-102
- Čerengsodnam 1993 - D.Čerengsodnam. *Mongyul-un niγuča tobčiyun-u orčiγulγa tayilburi. Ündüsüten-ü keblel-ün qoriy-a, Kökeqota*. 1993 он.
- Bürintögüs 1997 - Bürintögüs. *Mongyol jang üyile-yin nebterkei toli, aju aqui-yin boti, Öbür mongyol-un sinjilekü uqayan twknig mergejil-ün keblel-ün qoriy-a. Kökeqota*, 1997.
- Norjin 1999 - Č.Norjin, Mang Mören. *Mongyol kelen- ü toli. [Монгол хэлний толь] Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a. Kökeqota*. 1999.
- Sečenčoytu 1988 - Sečenčoytu. *Mongyol üges-ün iγayur-un toli. [Монгол үгийн язгуурын толь] Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a. Kökeqota*. 1988.
- Mongyul kitad toli, [Монгол хятад толь] öbür mongyul-un arad-un keblel-ün qoriy-a, Kökeqota*. 1999.
- Wanjil, *Mongyul ündüsüten-ü tariyalang, [Монгол үндэстний тариалан] öbür mongyul-un arad-un keblel-ün qoriy-a, Kökeqota*. 1999.
- Qurca 2001 - Qurca, Cang ming. *Qorčín tobčiyun. [Хорчин товцоон] Ündüsüten-ü keblel-ün qoriy-a. Kökeqota*. 2001.
- Bayančoytu 2002 - Bayančoytu. *Qorčín aman ayalyun-u sudulul. [Хорчин аман аялгууны судлал] Öbür mongyol-un yeke surγayuli-yin keblel-ün qoriy-a. Kökeqota*. 2002.
- Sengge 2004 - Č.Sengge. *Mongyol erten-ü angnal soyul-un sudulal. [Монгол эртний агнал соёлын судлал] Ündüsüten-ü keblel-ün qoriy-a. Kökeqota*. 2004.
- P. Rykin, *The Social Group and its Designation in Middle Mongolian: The Concepts irgen and obog, Forum for Anthropolgy and Culture*, 1, 2004, 183-210
- I. de Rachewiltz , *The Secret History of the Mongols*, I. 2004, p81
- Jerry Norman, *Comprehensive Manchu–English Dictionary, Harvard-Yenching Institute Monograph Series*, 85, 2013, 150 pp.

Abstract

Written language is divided into two types: "Library language" and "Oral written language". In addition, there are many studies that have analyzed a single written primary source in the field of Mongolian lexicology, but the study that used the oral text (transcriptions of audio recordings) of the "tales of the fiddle" has not been seen so far, therefore we considered our research object as an "oral and written primary source" (aman ba bichgiin survalj).

We chose the "Romance of the Three Kingdoms (in Mongolian: *γurban ulus-un üliger*; in Chinese: 三国演义)" which was performed by Bürenbayar bard (*quyurči*, Lit: the fiddle player) as a main object of our research work. In our research, we diachronically compared this version of the "Romance of the Three Kingdoms" with its different translations in Mongolian in order to identify features of the Khorchin (Qorčin) dialect that based on examples of the "tales of fiddle" that was performed by Khorchin bards.

In August 1984, Bürenbayar, an important source of the Khorchin dialect, performed the tale of the fiddle "Romance of the Three Kingdoms" for a total of 62 hours on the Khulunbuir Radio Committee. When we studied this tale of the fiddle from perspectives of the lexicological study, we revealed that the study of local/regional dialects and loan words was still lacking in the research field of tales of the fiddle.

However, 14 archaic words of Khorchin dialect, 18 words with phonetic changes, 9 words which are different for morphological structures than other Mongolian dialects, 22 words which are different for stylistic feature and its usage even though which are same to other dialects, and 18 distinct words were classified and explained.

Keywords: Oral written language, Khorchin dialect, archaic words, tales of the fiddle, Romance of the Three Kingdoms

Санхүүжилт: “Тус өгүүлэл нь БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны суурь мөнгөний анхаарагдаагүй буюу уламжлал тасарсан шинжилгээний салаагийн тусгай төсөл-Төвийн Үндэстний Их Сургуулийн Дунддын үндэстний уламжлалт соёлын солилцооны судлалын багийн төсөл болох “Монгол үндэстний аман уламжлал хийгээд монгол, хятад соёлын уусалцал” (20VJXT008)-ийн шатагч чанартай бүтээлийн хүрээнд бичив.